

ХОРТ БОДИСЫН ҮНЭН

ЭНЭ БОЛ ТРАФИГУРА
ХЭМЭЭХ ҮНДЭСТЭН
ДАМНАСАН
КОРПОРАЦИ, ПРОБО
КОАЛА ХЭМЭЭХ
ХӨЛӨГ ОНГОЦ,
ЗААНЫ ЯСАН ЭРЭГ
ДЭХ ХОРТ БОДИСЫН
ХАЯГДЛЫН ТУХАЙ
БИЛЭЭ

GREENPEACE

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



ГАРЧИГ

“ХОРТ БОДИСЫН ҮНЭН”

ХАЯГДАЛ: ЮУНААС ГАРЧ, ХААНААС ИРЭВ

- ДАЛАЙ ДЭЭР ЦЭВЭРЛЭХ АЖИЛЛАГАА
- ЕВРОП ДАХ ХАЯГДАЛ
- АФРИК ДАХ ХАЯГДАЛ
- ХАЯГДАЛ ХАЯХ
- ЭРҮҮЛ МЭНД БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАМШИГ

ХЭН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХ ЁСТОЙ ВЭ?

- КОРПОРАЦИЙН ГЭМТ ХЭРЭГ
- ТРАФИГУРАГИЙН ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ХАРИУЦЛАГА
- КОТ Д’ИВУАР: ТӨР ЗАСГИЙН АЛДАА
- НИДЕРЛАНД: ТӨР ЗАСГИЙН АЛДАА
- ИХ БРИТАНИ
- ХАРИУЦЛАГА
- МЭДЭЭЛЛИЙГ НЭЭЛТТЭЙ БАЙЛГАХ

ЗӨВЛӨМЖ

“ХОРТ БОДИСЫН ҮНЭН”

ЭНЭ БОЛ ТРАФИГУРА ХЭМЭЭХ ҮНДЭСТЭН ДАМНАСАН КОРПОРАЦИ, ПРОБО КОАЛА ХЭМЭЭХ ХӨЛӨГ ОНГОЦ, ЗААНЫ САН ЭРЭГ ДЭХ ХОРТ БОДИСЫН ХАЯГДЛЫН ТУХАЙ БИЛЭЭ¹

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ, ГРИЙНПИЙС БАЙГУУЛЛАГЫН ХАМТАРСАН ТАЙЛАНГИЙН
ХУРААНГУЙ

“2006 оны 8 дугаар сард манай гэр бүлийнхэн, хөршүүд гээд бүгд хордсон. Бидэнд дахиж ийм гамшиг хэзээ ч бүц тохиолдоосой. . . . Бидэнд амьсгалах үнэхээр хүнд байсан. Эхлээд амьсгалахын аргагүй үнэр ханхалж тэгээд бид амьсгалж чадахаа больсон. . . . 9 дүгээр сарын 2-ноос би ажилдаа явж чадахаа больж, орноосоо ч өндийж чадахгүй бүтэн долоо хоног хэвтсэн. Тэгээд 9 дүгээр сарын 11-нээс ажилдаа эргэж орсон. Хүцхдүцдийн маань нүд улайж, халуурч бас нэг хүцхэд маань суулгаж эхэлсэн. Тэд дор хаяж 2 долоо хоногийн турш халуурсан. Манай гэр бүлийнхэн бүгдээрээ хордлогонд орсон. Тухайн үед эхнэр маань жирэмсэн байсан учраас би түүнийг эндээс өөр газар руу явуулахыг хүссэн.

..... ойр хавийн айл хөршүүд маань бүгд өвдсөн. Ерөнхийдөө толгой өвдөх, халуурах, ханиалгах, цээжээр хөндцүрлэх, амьсгалын замын элдэв зовиур, загатнах, биеэр батга гарах, бөөлжих, хоол боловсруулах тогтолцоонд асуудлууд гарах зэрэг шинж тэмдэгүүд илэрч байсан.

..... хэрвээ та нар миний мэдцүлгийг авах юм бол намайг болон миний төлөөлж буй бусад хохирогчдын дуу хойлойг хүмүүс сонсох болно.

ЖА, Абобо- Плакү 1-р хэсгийн хохирогч

Кот д'Ивуарын Абиджан хотын иргэд 2006 оны 8 дугаар сарын 20-ний өглөө сэрэхэд хот тэр чигтээ нэгэн үнэрт автсан байв. Гэрчүүдийн дүрсэлж байгаагаар их өтгөн, амьсгал боосон, муудсан өндөг, сармис, газ болон бензин холилдсон сонин үнэр байжээ. Энэ нь хотын эргэн тойронд сургууль, гэр, ажил, ногооны талбай зэрэг 18 газар шөнийн цагаар асгаж хаясан хорт хаягдлаас ялгарч буй үнэр байв.

¹ Дэлгэрэнгүй илтгэлийг <http://www.amnesty.org/en/library/info/AFR31/002/2012/en> цахим хуудсаас үзнэ үү.

Тэвчихийн аргагүй үнэр олныг нилээдгүй түгшээж байсан бол үүнээс улбаалсан биет илрэлүүд нь жинхэнэ сандралд хүргэсэн юм. Мянга мянган хүмүүс дотор эвгүйргэх, толгой өвдөх, бөөлжих, гэдэс өвдөх мөн арьс, нүд загатнах зэрэг зовиур амсжээ. Хорт бодисыг хаяснаас хойших хугацаанд дээрх зовиур бүхий хэдэн арван мянган хүн тусламж авахаар эмнэлэгт хандсан байна. 2006 оны 10 дугаар сарын байдлаар эмнэлэгт 100,000 гаруй хүн хаягдлын улмаас хандсан тухай бүртгэгджээ. Орон нутгийн эрх баригчид 15-17 хүн хаягдлын уршгаар нас барсан хэмээн үзжээ.

Хорт бодисыг хаяснаас хойших эхний хэдэн сарын хугацаанд уг хаягдал эрүүл мэнд, бие махбодид хүчтэй нөлөөлж байгаа тухай тодорхой бичиж, тэмдэглэсэн байгаа боловч, зарим хүмүүс үүнээс ч урт хугацаанд зовиурласан байна. Хорт бодисыг зайлуулж, тухайн газрын цэвэрлэхэд хугацаа алдсан, хангалтгүй гүйцэтгэсэн зэрэг нь өдгөө хүртэл хорт бодисын ул мөр эрүүл мэндэд нөлөөлөх вий гэсэн айдсыг төрүүлж байна. Хорт бодис нь урт болон богино хугацаанд эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж буйг шалган дүгнэх эрүүл мэндийн үзлэг, өвчний тархалтын судалгааг огт хийгээгүйгээс гадна хаягдал нь чухам юунаас бүрдэж байгаа тухай бүрэн мэдээллийг олон нийтэд мэдээлээгүй юм. Иймэрхүү олигтой мэдээлэл байхгүй нөхцөлд олон хүн эрүүл мэнддээ санаа зовинох нь зүйн хэрэг.

2006 оны 8 дугаар сард Абиджанд хаясан хаягдал Трафигура гэх газрын тос борлуулдаг компанийх байсан юм. Уг хаягдал нь Трафигура компанийн захиалгаар Пробо Коала гэх усан онгоцоор Кот д'Ивуар буюу Зааны ясан эрэг улсад ирсэн ажээ. Гэхдээ уг хаягдал нь Европт бий болсон бөгөөд олон улсын хуулийн дагуу Зааны ясан эрэгт очих үндэслэлгүй юм.

Абиджанд болсон хэргийг - Их Британийн шүүхийн оролцоотойгоор Трафигура компанийн дотоод цахим шууданг шалгах зэргээр бүтэн 3 жил мөрдөн шалгасны эцэст уг хаягдлыг хаяхад Трафигура компанийн гаргасан шийдвэрүүд зайлшгүй үр дагавар авчирсан болохыг Эмнести Интернэшнл болон Грийнпийс байгууллага олж тогтоосон юм.

Мөрдөн шалгах явцад мөн олон засгийн газрууд хүн ам, байгаль орчныг үр дүнтэй хамгаалж чадахгүй байгаа, олон улсын хуулийг сахиулах ёстой аливаа улсын тогтолцоо үндэстэн дамнасан корпорациудыг гүйцэж ажиллаж чадахгүй байгааг, үүний улмаас иймэрхүү компани, корпорациуд нь шүүн таслах ажиллагаанаас зугатаж, ял шийтгэлгүй ажиллах боломжийг олгож байгааг илрүүлсэн юм. Түүнчлэн бүх засгийн газар нөхцөл байдлыг үр дүнтэй залруулж чадахгүй байгааг харуулж байна.

ХАЯГДАЛ: ЮУНААС ГАРЧ, ХААНААС ИРЭВ

2005 оны сүүлээр Трафигура компани нь **coker naphtha** гэх боловсруулаагүй газрын тосыг их хэмжээгээр авах шийдвэр гаргасан байна. Тэд уг бүтээгдэхүүнийг хямд өртөгтэй болохоор нь шатахуунтай холихоор худалдан авчээ. 2009 онд Их Британийн шүүхийн оролцоотойгоор Трафигура компанийн дотоод цахим шууданг шалгахад уг компани нь энэхүү худалдан авалтаасаа асар их ашиг олно гэж төлөвлөсөн нь харагдаж байжээ.

"PMI trading" ХХК их хэмжээний хүхрийн хий агуулдаг coker naphtha-г маш хямд үнээр зарж байсны учир нь тэдэнд үүнийг боловсруулах боломж байгаагүй аж. Тиймээс ч Трафигура coker naphtha-г боловсруулах арга олох хэрэгтэй болсон.

Трафигура натрийн исэл ашиглан coker naphtha боловсруулахаар шийдсэн байна. Уг аргаар боловсруулах нь хорт хаягдал үүсгэдэг болохыг Трафигура маш сайн мэдэж байжээ. 2008 оны 9 сарын 28-ны өдөр Трафигурагийн захирал Клауде Дауфин болон бусад ажилтан руу илгээсэн нэгэн цахим шуудандаа Лондон хотод байрладаг нэгэн ажилтан

“Энэ үйл ажиллагааг (хүхрийн хийгээр угаах) Европын Холбоо, АНУ болон Сингапурт хориглосон. Боловсруулалтаас гарч буй хаягдал нь хортой (хий, фенол-карбоны хүчил, үнэр) учраас ихэнх орнуудад уг боловсруулах ажиллагааг хориглодог бөгөөд зах зээл дээр иймэрхүү хаягдлыг хүлээн авах газар байхгүй байгаа тул нийлүүлэгчид хаягдлыг хариуцан хаяхаас татгалзаж байна. Роттердамд иймэрхүү төрлийн хаягдлыг шатаадаг нэгэн компани байдаг ба кг хаягдлыг 200 ам.доллараар шатаадаг. Гэхдээ боловсруулах үйлдвэрлэлээс гарсан идэвхижсэн хаягдлыг шатаахад кг тутам нь 1000 гаруй доллар болох юм шиг байна. Европын холбооны хуулийн дагуу иймэрхүү төрлийн хаягдлыг Европын Холбооны газар нутгаар тээвэрлэхийг хориглодог” гэж бичжээ:

ХУУЛЬ ЭРХЗҮЙН ХҮРЭЭНД

Хорт хаягдлыг хууль бусаар хаях нь ихэвчлэн хөгжиж буй орнуудад болдог бөгөөд энэ нь олон улсын хэмжээнд байгаль орчин, хүмүүсийн хүний эрхэд ноцтой асуудал гэж үздэг. Олон улс, бүс нутаг болон улс орнуудын хэмжээнд аюултай хорт бодис болон хаягдлын устгалд хяналт тавих зорилготой хэд хэдэн хууль эрх зүйн баримт бичиг байгуулсан байдаг.

Аюултай хог хаягдлыг хил дамнуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенци (Базелийн конвенци)

Базелийн конвенци нь тусгайлан анхаарах шаардлагатай эсвэл хүний эрүүл мэнд болоод байгаль орчинд аюул учруулж болох аливаа хаягдлыг хянах, зохицуулах зорилготой олон улсын гэрээ юм. Уг конвенциор аюултай эсвэл бусад иймэрхүү төрлийн хаягдлыг хил дамнуулан тээвэрлэх, ингэхдээ тухайн хаягдлын аваачиж буй оронд урьдчилан мэдэгдэж, зөвшөөрлийг нь аваагүй, хуурамч мэдээлэл, бичиг баримт эсвэл залилан хийж тээвэрлэх зөвшөөрөл авсан, тухайн хаягдал нь бичиг баримттайгаа зөрөх, эсвэл санаатайгаар уг хаягдлыг зохих ёсны дагуу хаяаагүй (шууд асгах гэх мэт) бол хууль бус үйл ажиллагаа гэж үздэг. Түүнчлэн уг Конвенцид аюултай хог хаягдлыг хууль бусаар тээвэрлэх нь эрүүгийн гэмт хэрэг хэмээн заажээ.

ЕВРОПЫН ХОЛБООНЫ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ ЖУРАМ

Европын Холбооны Хаягдал Тээвэрлэх Журмын 18 дугаар хэсэгт ЕХ-ноос Африк, Карибын тэнгис болон Номхон далайн хэсэг орнууд (үүний дунд Кот д'Ивуар орж байгаа)-д Базелийн хог хаягдлыг тээвэрлэхийг хориглон, эрүүгийн хэрэг гэж үзсэн байна.

Усан онгоцны хэвийн үйл ажиллагааны улмаас гарч буй бохирдлоос сэргийлэх тухай олон улсын конвенц

Базелийн Конвенц нь хаягдал, тэр дундаа аюултай хорт хаягдал, асуудлыг зохицуулдаг боловч “усан онгоцны хэвийн үйл ажиллагааны улмаас гарч буй хаягдал”-г зохицуулдаггүй. Эдгээр хаягдлыг Усан онгоцны бохирдлоос Сэргийлэх тухай олон улсын Конвенц 1973/78 (МАРПОЛ Конвенц)-ын дагуу шийдвэрлэдэг. МАРПОЛ Конвенцийн гол зорилго нь газрын тос болон бусад хорт бодисын улмаас далай тэнгисийн эко-орчны бохирдолтыг зогсоох явдал юм. Эдгээр бодисыг хүлээн авах байгууламжид аваачиж устгах ёстой байдаг.

ХОРТ ХАЯГДАЛ БА ХҮНИЙ ЭРХ

Олон улсын хүний эрхийн дагуу улс орнууд нь иргэдээ аюултай хорт бодисоос хамгаалах үүрэг хүлээдэг. Олон улсын эдийн засаг, нийгэм соёлын эрхийн олон улсын конвенцийн 12 дугаар зүйлд “оролцогч улс орнууд бие бялдар болоод сэтгэцийн эрүүл мэндийн дээд түвшинд хүрсэн байх” хэмээн заасан байдаг. НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөл (ЭЗНЗ):

“12 дугаар зүйлд заасан олон улсын үүргээ биелүүлэхийн улс орнууд нь эрүүл байх эрхийг эдлэх явдлыг хүндлэх, эх оронд нь гуравдагч этгээд уг эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх ёстой бөгөөд хэрвээ боломж байгаа бол Нэгдсэн Үндэсний Байгууллагын дүрэм болон бусад холбогдох олон улсын хуулийн дагуу хууль, улс төрийн арга замаар гуравдагч талд нөлөөлөх хэрэгтэй” гэжээ.

Улс орнууд нь өөрийн газар нутгаасаа гаднах хүний эрхийн асуудалд анхаарал тавих үүрэгтэй болохыг тус Зөвлөлийн зүгээс хүлээн зөвшөөрч буй нь хүний эрхийг хамгаалахад иймэрхүү хариуцлага чухал нөлөөтэй болохыг хүлээн зөвшөөрч эхэлсэний илэрхийлэл билээ. Дор хаяж, бусад орон дах эрүүл байх эрхийг хүндлэнэ гэдэг нь улс орнууд бусад улсын эрүүл байх эрхэнд халдах аливаа эрсдлийг тооцож үзэх ба хуулийн болон техникийн боломж байгаа бол шаардлагатай арга хэмжээ авах үүрэгтэй болж байгаа юм.

ДАЛАЙ ДЭЭР ЦЭВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

Трафигура нь эх газар дээр уг боловсруулах ажиллагааг явуулах үйлдвэр олж чадахгүй байв. 2006 оны 1–3 дугаар сарын хооронд Тунисын боомтод 2 удаа боловсруулах ажиллагаа явуулсан байна. Гэвч хаягдлыг боловсруулах явцад газар хий дайварлан гарч эрх баригчид тухайн боомт нь иймэрхүү төрлийн хаягдлыг устгах байгууламж байхгүй учраас уг цэвэрлэх ажиллагааг зогсоосон байна. Үүний дараа Трафигура компанийхан боловсруулах үйлдвэрлэлээ далайд явж буй усан онгоцон дотор хийх болжээ. Боловсруулах үйлдвэрлэл явуулж байсан онгоцыг Пробо Коала гэдэг.

Трафигура далай дээр үйлвэрлэлийн үйл ажиллагаа явуулахаар шийдвэрлэх үедээ гарах хаягдлыг яаж зайлуулахаа мэдэхгүй байсан боловч уг хаягдал нь аюултай гэдгийг маш сайн мэдэж байжээ. Далай дээрх эхний боловсруулах ажиллагаа 2006 оны 4 сарын дундуур дууссан байна. 2006 оны 6 сарын сүүлээр Пробо Коала онгоц Гибралтараас Амстердам руу хойд зүгийг чиглэн явах замд нийт 3 онгоц **coker naphtha** угаасан ажээ. Нийт 500м³ хаягдал онгоцны хадгалах саванд хуримтлагдаад байсан ч Трафигура компанийхан үүнийг устгах арга олж чадахгүй хэвээр байна.

ЕВРОП ДАХ ХАЯГДАЛ

2006 оны 4 дүгээр сард Трафигура хаягдлаа буулгахаар Европт 4 газарт ханджээ. Эдгээр газрын аль нь ч хаягдлыг хүлээн авахаас татгалзсан бөгөөд энэ нь уг хаягдалд илүү тусгай боловсруулалт шаардлагатай байсантай холбоотой юм. 2006 оны 6 дугаар 19-нд Трафигура нь усан онгоцны хаягдал боловсруулдаг Голланд компани болох Амстердам Порт Сервис (АПС) гэх компанитай холбоо тогтоож, хаягдлаа буулгахаар болсон байна. АПС нь албан ёсоор томилогдсон боомтын хүлээн авах байгууламж бөгөөд МАРПОЛ-ын Конвенцийн дагуу усан онгоцны хаягдлыг хүлээн авах эрхийг Голландын эрх баригчид олгожээ. Гэвч удалгүй Трафигура АПС-д хаягдлын шинж чанарын талаар хангалттай мэдээлэл өгөөгүй болох нь илэрсэн байна.

Пробо Коала 2006 оны 7 сарын 2-нд Амстердамд ирсэн бөгөөд АПС хаягдлыг даруй буулгаж эхэлжээ. Маргааш өглөө нь буюу 2006 оны 7 сарын 3-нд Голландын эрх баригчид уг газарт маш тааламжгүй үнэр гарч буй тухай гомдол хүлээн авч, гал команд болон цагдаа дуусан байна. АПС-ын барилгын ойролцоо ажилладаг нэгэн эмэгтэй эрх баригчдыг дуудсан шалтгаанаа тайлбарлахдаа:

“Химийн бодисын үнэр үнэртээд байсан. Толгой эргээд, дотор эвгүй оргиод байсан. Мөн миний хүзүү маш их загатнаж, толгой маш аймшигтэй өвдөөд байсан юм. 9 цаг хагасын үед би ажил дээрээ байсан ба муухай үнэр үнэртэж байсан ч яг тухайн үед миний бие харьцангуй гайгүй байсан. Тэгээд 11 цагийн үед цагдаа руу утасдсан. Утасдах үед үнэр нь бүр ихсэж, манан татсан юм шиг л болсон байсан... тэр өдөр надад ямарч хоолны дуршил байгаагүй. 5 цагийн үед гэртээ харьсны дараа ч миний толгой эргэж, дотор эвгүй оргисон хэвээр байсан” гэжээ.

АПС тухайн хаягдлаас дээж авч шинжлэхэд АПС-ын төсөөлж байснаас хамаагүй өндөр хэмжээний Химийн хүчилтөрөгчийн хэрэгцээ (XXX, бохирдлын шууд бус хэмжүүр) илэрсэн юм. Уг шинжилгээний үр дүн мөн уг хаягдлыг өөр нэгэн мэргэшсэн байгууллагад өгөн устгах ёстой болохоор АПС анх тохиролцсон үнээ м3 тутам нь \$27 (US\$) байсныг \$1000 (US\$)(анхны үнээ 37 дахин өсгөсөн) болгон өсгөсөн байна. Трафигура өндөр төлбөр төлөхөөс татгалзсан бөгөөд АПС-ыг хаягдлыг буцаан Пробо Коалад шахахыг хүсчээ.

Уг хаягдлын үнэр, Трафигурагийн хаягдлыг Пробо Коалад буцаад ачих хүсэлт нь нилээдгүй ер бусын байсан тул хууль сахиулах байгууллагынханы санааг зовоосон

байна. 2006 оны 7 сарын 3-4-ний өдрүүдэд орон нутгийн эрх баригчид уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар нилээдгүй яриа хэлэлцүүлэг явагджээ. Голландын байгаль орчны хуулийн дагуу уг хаягдлыг буцаан онгоцонд ачихыг хориглох боломж байсан ч эрх баригчид хаягдлыг дахин ачиж, Пробо Коалаг Нидерланд улсыг орхин явахыг зөвшөөрсөн байна. Уг усан онгоц Эстонид богино хугацаагаар зогссоны дараа хаягдлаа тээсээр Европыг орхин Баруун Африкийн зүг явжээ.

АФРИК ДАХ ХАЯГДАЛ

Цахим шуудангаас үзэхэд Трафигура хаягдлаа Нигер улсад хаях гэж оролдсон боловч хаях чадаагүй болох нь харагдаж байна. Нигерээс гараад Пробо Коалаг Кот д'Ивуарын Абиджан руу чиглэхийг Трафигура компаниас зааварчилжээ. Усан онгоц Абиджаны боомтод ирэх үед Трафигура нэгэн шинэхэн байгуулагдаж, тусгай зөвшөөрлөө авсан "Томми" гэх жижиг компанитай гэрээ байгуулсан байна. Үүнд хаягдлыг МАРПОЛ-ын бус зүгээр л химийн хаягдал хэмээн бичжээ.

Гэрээнд — гараар бичсэн тэмдэглэл- Томми компани нь "хотын гадна "Акоуедо" гэх газар хаягдлыг хаяна" хэмээнд заасан байна. Акоуедо нь Абиджаны орон сууцны хороололд байрлах гэр ахуйн хаягдалд зориулсан нээлттэй хогийн цэг юм. Энд аюултай хог хаягдлыг хадгалах, боловсруулах байгууламж огт байхгүй. Уг хог хаягдлын эзэн болохынхоо хувьд Трафигура компани нь уг хаягдалтай зохистой харьцах, угстгах зэрэгт анхаарал тавих үүрэгтэй билээ.

Гэрээнээс үзэхэд "Томми"-гийн зүгээс санал болгосон үнэ нь Трафигура компани нь уг хаягдлыг устгасны төлөө Европ улсуудад төлөхөөс харьцангуй бага байна. Гэрээний дагуу Томми нь МАРПОЛ-ын хаягдал бол м3 тутамд \$30 ам.доллар, химийн хаягдлын тухайд м3 тутамд \$35 ам.долларын төлбөр авахаар тусгажээ. Энэ нь Нидерланд улсад хаягдлыг хаях АПС-ын \$1000 ам.долларын үнийн саналаас эрс ялгаатай байгаа юм. Хаягдлыг химийн хаягдал гэдгийг нь мэдсээр байж Томми яагаад МАРПОЛ-ын хаягдалд үнийн санал өгсөн нь тодорхойгүй байна.

Түүнчлэн Томмигийн өгсөн үнийн санал нь уг төрлийн хорт бодисыг зайлуулах, хаях ажлын хувьд хэт доогуур үнэтэй болохыг Трафигура мэдэж байсан нь гарцаагүй. Голландын цагдаа нар уг хаягдлын асуудлаар Трафигура руу утасдаж, үнийн саналтай танилцахыг хүсэхэд Трафигура "Томми"-гоос илүү өндөр үнэтэй хуурамч нэхэмжлэл гаргаж өгөхийг хүссэн байна.

ХАЯГДАЛ ХАЯХ

Абиджанд хаягдал ирмэгц ачааны машинд ачин, Акоуедо хогийн цэг дээр авчирсан байна. Гэвч эхний хэдэн машин хаягдлыг буулгахад маш хурц үнэртэж, хогийн цэгийг хаахад хүржээ. Хогийн цэг хаагдаж, "Томми"-той холбогдож чадаагүй жолоочид сандарч, хаягдлаа Абиджаны эргэн тойронд сургууль, ажлын байр, орон сууцнууд, тариан талбай, шорон зэрэг хаа дайралдсан газраа асгацгаасан байна.

ЭРҮҮЛ МЭНД, БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАМШИГ

Пробо Коалагийн 523м³ хорт хаягдлыг хамаагүй хаясны улмаас 2006 оны 8 дугаар сарын 19-ний Бямба гаригаас хойш Кот д'Ивуарт хүмүүнлэгийн болон байгаль орчны гамшиг нүүрлээд байна.

Уг явдлаас хойших хугацаанд мэдрэл, хоол боловсруулах тогтолцоо, амьсгалын зам, чих, хамар, хоолой, хараа болон бусад эрүүл мэндийн асуудлаар шаналсан хэдэн арван мянган иргэд эрүүл мэндийн төв болон эмнэлэгүүдэд ханджээ. Болсон хэрэг явдалд уурлаж мөн айсан иргэд хот даяар жагссан байна. Хэт их үнэр, эрүүл мэндэд гарч буй нөлөө зэрэг нь үлэмж хэмжээний айдас, түгшүүр төрүүлсэн юм. 2006 оны 9 дүгээр сарын эхээр "бохирдолд өртсөн иргэдийн өвчлөлт, тоо, өвчний хурцадмал байдал зэрэг нь олны нийтийн дунд айдас түгшүүрийг төрүүлж байна" хэмээн Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага тэмдэглэжээ.

ХЭН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХ ЁСТОЙ ВЭ?

КОРПОРАЦИЙН ГЭМТ ХЭРЭГ: ТРАФИГУРАГИЙН ХАРИУЦЛАГА

Трафигурагийн зүгээс 2006 онд Абиджанд болсонд үйл явдалд манай компани ямарваа хариуцлага хүлээхгүй хэмээн удаа дараа мэдэгдсэн юм. Гэвч Голландын шүүх Трафигураг хууль бусаар хаягдлыг Европоос экспортлосон буруутай хэмээн үзэж, Кот д'Ивуарт хаягдлаа асгасан хэрэгт нь компанийн хариуцлага тооцохоор мөрдөн шалгалт явуулсан байна.

Нотлох баримтуудаас харахад байгаль оршин болон хүний эрүүл мэндэд маш аюултай хаягдал үйлдвэрлэсэн гэдгээ Трафигура сайн мэдэж байсан байна. Түүнээс гадна уг хаягдлыг Европоос Африк тив рүү тээвэрлэх нь хууль бус гэдгийг ч Трафигура мэдэж байсан, мэдээгүй байлаа гэхэд мэдэж байх үүрэгтэй байсан юм. Хаягдал нь зайлшгүй тусгайлан хаяж устгах ёстой, Европын дөрвөн ч байгууллага уг хаягдлыг устгаж чадахгүй, 5 дах нь тусгай боловсруулалт шаардлагатай гэдгийг онцгойлон мэдэгдсэнийг мэдсээр байж Абиджан дах орон сууцны хорооллын дунд нээлттэй хогийн цэг дээр хаяхаар шинэхэн компани сонгон гэрээлсэн байна.

Трафигура аюултай гэдгийг нь мэдсээр байж хорт хаягдлыг зохих байдлаар хаяж, устгаагүйгээс гадна, хаягдлын шинж чанарын талаар хууль тогтоогч байгууллага болон харилцагч компаниуддаа зөв мэдээлэл өгөөгүйгээс хаягдлыг зохистой устгахгүй байх эрсдэлд шууд хүргэсэн юм.

Хаягдлыг хаясны дараахан Кот д'Ивуарт ирсэн Трафигурагийн хоёр дээд удирдах ажилтнууд болох Клауде Дауфин ба Жан- Пьер Валентини нарыг баривчилж, олон зүйл ангиар хэрэгт татсан байна. Гэвч 2007 оны 2 сарын 13-нд Кот д'Ивуарт болон Трафигура зөвшилцөлд хүрч, Трафигура CFA95 тэрбум (ойролцоогоор \$200 сая ам.доллар) төлөхөөр болсон юм. Ивуарын Хэлэлцээрийн дагуу нөхөн төлбөрийн хариуд засгийн газар нь Трафигурагийн талыг “уг хэргээр одоо эсвэл ирээдүйд шүүх, заргалдах эсвэл ямарваа арга хэмжээ авах” эрхээсээ татгалзсан байна. Хоёр удирдлагыг батлан даалтаар суллаж, хэргийг хаажээ.

2010 онд Голландын шүүх Трафигураг Кот д'Ивуарт хууль бусаар хаягдал экспортолсон, компани хаягдлыг боловсруулахаар Амстердамд авчрахдаа “хаягдлын хорт шинж чанарыг нуун дарагдуулсан”-ы төлөө ял оноосон байна. Гэвч Прокурор хаягдлыг Голландын газар нутгаас гарснаас хойших хэрэгтэй холбоотойгоор компанийг шалгахгүй байхаар шийдвэрлэсэн байна.

Иргэд ч мөн арга хэмжээ авахуулахаар оролдсон байдаг. Их Британийн шүүхэд хандсан ч хэргийг шүүхийн гадуур шийдвэрлэсэн бол хохирогчид Голландын шүүхэд хандсан ч амжилт олж чадаагүй ажээ. Голланд эрүүгийн гэмт хэрэгт Абиджанд болсон хэргийг шүүх эрх мэдэл байддаггүй бөгөөд энэ нь хохирогчдын иргэний арга хэмжээ авах боломжийг ихээхэн хязгаарлаж байна.

Трафигурагаас тайланд гарсан мэдэгдэлд хариу өгөхийг хүсэхэд:

“Уг тайлан ноцтой алдаатай, ташаа мэдээлэл болсон гэж манай зүгээс үзэж байна. Тайлан нь тун хэцүү төвөгтэй хууль шүүхийн асуудлыг хэт энгийн мэт тайлбарлаж, буруу ташаа мэдээлэл дээр үндэслэн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан байгаа нь нөхцөл байдлын нарийн учир, процессийг илтгэж чадахгүй байна. Уг хэргийг 5 орны шүүх байгууллага өөр өөр талаас нь шалган үзэж, зохих шийдвэрүүдээ гаргаж, зөвшилцөлд хүрсэн. Тиймээс уг хэргийг хангалттай хууль шүүхийн байгууллагаас шалгаагүй гэх нь буруу” хэмээн хариулсан юм. Гэвч Трафигура ямар алдаа, ташаа мэдээлэл гарсан талаар тодорхой хэлсэнгүй.

ТРАФИГУРАГИЙН ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ХАРИУЦЛАГА

Кот д'Ивуар: Компанийг ялаас чөлөөлсөн

Нидерланд: Хаягдлыг экспортолсон хэргээр шүүж, гэм буруутай хэмээн үзэж 1 сая еврогоор торгосон. Давж заалдах шатны шүүх хурлаар мөн гэм буруутай хэмээн үзжээ. Прокуророос Кот д'Ивуарт болсон хэргийг мөрдөн байцааж, шүүхгүй байхаар шийдвэрлэсэн юм. Мөн Грийнписийн зүгээс Абиджанд хаягдал тээвэрлэж байсан жолоочид Трафигура эсвэл Трафигурагийн ажилтны зүй бус нөлөөгөөр уг хаягдлыг хаа сайгүй хаясан гэх мэдээлэлд шалгалт хийж, мөрдөн байцаалт явуулах асуудлаар хүсэлт гаргахад Голландын шүүх эрх мэдлийн хүрээнд хамаарахгүй хэмээн хүсэлтийг буцаажээ.

Их Британи: 30,000 гаруй хохирогчид иргэний хэрэг үүсгэсэн боловч шүүхийн гадуур шийдвэрлэсэн. Ямарваа эрүүгийн мөрдөн шалгалт явуулаагүй.

Франц: Клауде Дауфин ба Жан-Пьер Валентини гэх Трафигурагийн Франц гаралтай хоёр удирдлагыг Францын Прокурор шүүхгүй байхаар шийдвэрлэжээ.

Норвеги: Иймэрхүү ижил төрлийн хаягдлыг Норвегид авчирсан хэдий ч усан онгоцон дээр үйлдвэрлэсэн хаягдал гэх шалгаанаар Трафигура шүүх ажиллагаанаас зайлж байна.

КОТ Д'ИВУАР: ТӨР ЗАСГИЙН АЛДАА

Кот д'Ивуар хаягдал хаясны дараа түргэн шуурхай арга хэмжээ авч, үнэгүй эрүүл мэндийн үйлчилгээгээр хангаж чадсан ч, Трафигурад ялаас зугатах боломжийг олгосон. Үндэсний Мөрдөн Шалгах Коммисс хаягдлыг хаясны дараа мөрдөн байцаалт явуулсны үр дүнд анхнаасаа эрх баригчид эрх зүйн ноцтой алдаа гаргаж, хаягдыг хилээр орж ирэх боломжийг олгосон болохыг тогтоосон байна. Тухайлбал, Томмид Абиджаны боомтод үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон нь учир дутагдалтай мөн зохих шалгалт хийлгүйгээр тусгай зөвшөөрөл олгосон байжээ. Боомтын үйл ажиллагаа, зохицуулалт болон Акоюедод тавьдаг хяналт шалгалт тун хангалтгүй хэмээх шүүмжлэлд өртжээ. Абиджаны иргэдийг хамгаалах ёстой хууль тогтоомжийг сахиулж чадаагүй юм. Хилээр хорт бодис нэвтрүүлэхгүй байх хуулийг сахиулж чадаагүйн улмаас өөрийн засаг захиргаан дах иргэдийнх нь эрхийг Трафигура, Томми зэрэг компаниуд зөрчихөөс хамгаалах шаардлагатай бүхий л арга хэмжээг Кот д'Ивуарын засгийн газар авч чадаагүй юм.

Мөн Кот д'Ивуарын засгийн газар нь Олон улсын эдийн засаг, нийгэм соёлын эрхийн олон улсын конвенциор хүлээсэн эрүүл байх эрхийг хамгаалах үүргээ мөн хууль бус тээвэрлэлт, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлгүй этгээдээр хорт бодисыг импортлуулах эсвэл хаяхаас сэргийлэх Базел болон Бамакогийн конвенциудаар хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй байна.

НИДЕРЛАНД: ТӨР ЗАСГИЙН АЛДАА

Уг хаягдлын талаар хамгийн сайн мэдээлэлтэй улс нь Нидерланд байсан ба хаягдлыг экспортлох, цаашилбал хаягдлыг хаях явдлаас урьдчилан сэргийлэх боломжтой байсан юм. Нидерландын засгийн газар Трафигура хаягдлыг МАРПОЛ-ын хаягдал хэмээн тайлбарлаж, төөрөгдүүлсэн хэмээн маргах гэж оролдож байна. Гэвч энэ бол ямарч үндэслэлгүй тайлбар билээ.

Трафигурагаас авсан мэдээлэл Нидерландын засгийн газар хүлээн авсан цорын ганц мэдээлэл биш байсан. Нидерландын эрх баригчид Пробо Коалаг боомтыг орхин явахыг зөвшөөрөх үедээ хаягдлын үнэр олон нийтийн санааг зовоож, толгой эргэх, өвдөх, дотор эвгүйрэх зэргээр хүмүүсийн эрүүл мэндэд нөлөөлж байсныг мэдэж байсан. Түүнчлэн хаягдалтай харьцах тал дээр нилээдгүй туршлагатай АПС хүлээн авах байгууламж уг хаягдлыг хүлээн авах боломжгүй байсныг тодорхой мэдэж байсан билээ. Голландын эрх баригчдад уг хаягдал нь хүний эрүүл мэндэд эрсдэл учруулахуйц хортой гэж дүгнэх хангалттай баримт нотолгоо байсан. Трафигура нь Голландад хаягдлыг зохих ёсны дагуу боловсруулан хаяснаас үүдэн гарах нэмэлт зардлыг төлөхгүйн тулд хаягдлаа тээвэрлэн Амстердамаас явсан.

Голландын эрх баригчдад уг хаягдлыг зохих ёсны дагуу аюулгүй хаяж устгана гэх баталгаа байхгүй гэдгийг ч сайн мэдэж байсан. Трафигура мөнгө заран уг хаягдлыг зохих ёсоор нь хаяж, устгах хүсэлгүй байсан учраас хаягдлаа аван Амстердамаас явсан

билээ. Түүнчлэн 2006 оны 7 дугаар сарын 3-нд эрх баригчид уг хаягдлыг далайд асгах гэж байна гэсэн нэргүй факс хүлээн авсан бөгөөд тэд уг факсыг маш ноцтойгоор хүлээн авч, бүх хаягдал очсон эсэхийг шалгахын тулд Эстонийн боомтын эрх баригчдаас боомт дээр ирсэн Трафигурагийн хаягдлыг хэмжихийг хүссэн байна.

2006 оны 7 сарын 2-4-ний хооронд Амстердамын эрх баригчдын хүлээн авсан мэдээлэл нь цаашдын арга хэмжээ авах, ядаж л уг хаягдлыг Нидерландыг орхин явахыг зөвшөөрөхөөсөө өмнө нэмэлт шалгалт явуулахад хангалтай үндэслэл болохуйц байсан юм. Үүнээс гадна тэдэнд холбогдох арга хэмжээ авах эрх зүйн боломж, бололцоо ч байсан юм. Эрх баригчдад Нидерланд улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй хэд хэдэн хуулийн дагуу онгоцыг шалгах, Амстердамыг орхин явахыг хориглох, Нидерландад уг хаягдлыг хаяж, устгахыг шаардах эрх зүйн боломж бололцоо бүрэн байсан билээ. Үүнээс гадна Нидерландын эрх баригчдад хаягдлыг Амстердамаас явахыг хориглох эрх зүйн эрх мэдэл байгаад зогсохгүй, тэд Европын болон олон улсын хуулийн дагуу ийм шаардлага тавих эрхтэй байжээ.

МАРПОЛ-ЫН ХАЯГДАЛ ХЭМЭЭН МЭЛЗСЭЭР Л...

Трафигура компанийн зүгээс хэд хэдэн удаа Пробо Коала онгоцон дээр бий болсон хаягдал учраас Базелийн конвенци болон Европын хаягдал тээвэрлэх журамд хамаарахгүй, энэ бол МАРПОЛ-ын хаягдал ("усан онгоцны хэвийн үйл ажиллагаанаас" гарсан) хэмээн мэтгэх гэж оролдсон юм.

Уг хаягдал нь МАРПОЛ-ын хаягдал гэх Трафигурагийн мэдэгдэл нь үндэслэлгүй. Бензинийг боловсруулахыг усан онгоцны "хэвийн" үйл ажиллагаатай хэмээн үзэж болохгүй харин энэ бол ер бусын үйл ажиллагаа байсан бөгөөд Трафигурагаас өмнө усан онгоцон дээр үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байсан тухай мэдээлэл байдаггүй. Олон Улсын Байгаль Орчны Хуулийн Төвөөс явуулсан шалгалтаар МАРПОЛ-д заасан хаягдал нь усан онгоц тээврийн хэрэгсэл болохынхоо хувьд гаргаж буй хаягдлыг хэлнэ хэмээн дүгнэсэн байна. Түүнчлэн Трафигурагийн өөрийнх нь мэдэгдэлээс үзэхэд тэд уг хаягдал нь МАРПОЛ-ын хаягдал биш гэдгийг мэдэж байсан болох нь харагдаж байна. Цаашилбал Абиджанд хаягдал хаяхаасаа өмнө Трафигура компани Пуматай 2006 оны 8 сарын 17-ны өдөр харилцах үеэрээ "Химийн хүчилтөрөгчийн хэрэгцээ нь 2000мг/л-ээс их байгаа тул **үүнийг МАРПОЛ-ын хаягдал бус химийн хаягдал хэмээн үзэхээс өөр аргагүй**" хэмээн бичсэн байдаг.

ИХ БРИТАНИ

Трафигурагийн бүлэг компанийн нэг болох Трафигура ХХК нь Их Британид бүртгэлтэй компани юм. Дотоод цахим шуудангаас үзэхэд уг компани нь гол гол шийдвэрлэх асуудлууд дээр Пробо Коала дээр үйл ажиллагаанд зааварчилгаа өгч байсан байна. Гэвч Их Британийн эрх баригчид ямар нэгэн байдлаар мөрдөн шалгалт, шүүх ажиллагаа явуулаагүй юм.

ХАРИУЦЛАГА

Энэ явдал үнэхээр үндэстэн дамнасан хэрэг юм. Хаягдлыг үйлдвэрлэж, тээрэвлэх болон хаях зэрэг нь бүгд өөр өөр орнуудад, дэлхийг тойрон явсан бөгөөд Трафигура уг хаягдлыг Газрын дунд тэнгисээс Нидерланд, Эстони, Нигер болон Кот д'Ивуар хүртэл тээвэрлэсэн байна. Ийнхүү хаягдлыг хууль бусаар тээвэрлэж, Трафигурагийн гэрээт компани болох "Томми"-гийн ажилчид хаягдлыг асгасан зэргийн үр уршгийг Абиджаны ард иргэд амсаж, эрүүл байр, эрүүл орчинд ажиллаж, амьдрах эрхээ зөрчүүлж байна.

Базелийн Конвенцийг чухамдаа яг ийм хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор байгуулсан билээ. Уг конвенциор олон улсын хэм хэмжээг тогтоох, улс орнуудын хоорондын хамтын ажиллагааг бий болгож аюултай хаягдлыг хил дамнуулан шилжүүлэхгүй байх зорилгоор байгуулсан юм. Энэ хэрэг явдал нь үндэстэн дамнасан корпораци хэрхэн улс орнуудын хуулийн цоорхойг ашиглан олон улсын хэм хэмжээ, эрхзүйн зохицуулалтыг тойрон гарч болдгийг харуулж байна. Улс орнууд хил дамнасан хөдөлгөөн, хорт хаягдлыг асгахаас сэргийлэх, иргэдийнхээ эрүүл байх эрхийг хамгаалах үүрэг хариуцлагаа биелүүлж чадахгүй байгаа тухай уг тайланд мөн бичжээ. Хэдийгээр

улс орнууд тодорхой хэмжээний оролдлого гаргасан боловч хохирогчдын үр дүнтэй хохирлоо барагдуулах эрхийг нь хангаж чадахгүй байгаа юм.

Олон улсын хуулийн дагуу, хэн нэгний эрхийг хэд хэдэн улс орнууд зөрчсөн бол тухайн этгээд нь бүтэн хохирлоо барагдуулж авах эрхтэй. Аливаа нэгэн улс орны буруутай үйлдлээс хохирсон этгээд хохирлоо барагдуулж авах эрхээ эдэлж чадаагүй тохиолдолд, тухайн улс орон нь үр дүнтэй хохирол барагдуулан авах боломжоор хангах үүрэгтэй юм.

Хэд хэдэн орон хууль эрх зүйн арга хэмжээ авч эхэлсэн боловч Кот д'Ивуарт гарсан эрүүгийн хэрэгт гэм буруутай талыг шүүх, хариуцлага хүлээлгэх асуудал дээр олон улсын хамтын ажиллагаа, зохицуулалт огт байгаагүй юм. Зарим талаараа эдгээр үйл ажиллагаа нь бие биеийнхээ эсрэг тоглож, шүүн таслах ажиллагааг болиулахад хүргэсэн байдал ажиглагдаж байна. Түүнчлэн Трафигура группыг бүхэлд нь бус ганцхан Кот д'Ивуар дах Трафигурагийн ажилтнуудыг л эрүүгийн хэргээр шүүхэд татсан байна. Кот д'Ивуарын хуулийн хязгаардлагдмал байдлын улмаас компанийг өөрийг нь шүүх, шүүх хэрэгт татах боломжгүй ажээ. Кот д'Ивуарын засгийн газар болон Трафигурагийн хооронд байгуулсан шүүхээс гадуур шийдвэрлэх гэрээний зүйл заалт, компанийн удирдлагууд Кот д'Ивуарыг орхин явсны улмаас Шийдвэр гаргах түвшний удирдах ажилтнуудыг шүүх ажиллагаа нь төдийлөн амжилттай явагдаж чадаагүй юм. Кот д'Ивуарт хорт хаягдлыг асгасан мөн түүний байгаль орчин болон хүний эрүүл мэндэд хохирол учруулсан хэргээр өөр корпораци этгээдийг шүүх ажиллагаа ямар ч орон явуулаагүй. Өөрөөр хэлбэл Трафигура Группын холбогдох бүх охин компаниуд өнөөг хүртэл уг хууль бус үйл ажиллагаандаа хариуцлага хүлээж, ял зэмгүй явж байна.

МЭДЭЭЛЛИЙГ НЭЭЛТТЭЙ БАЙЛГАХ

Уг хэрэгтэй холбогдсон аль ч улс Трафигураг хаягдлын найрлага, агуулга болон түүний хор уршгийн талаарх мэдээллийг хохирогчдод өгөхийг шаардаагүй юм. Хаягдлын найрлага, агуулга болон түүний хор уршгийн талаарх мэдээлэл байхгүйгээс Кот д'Ивуар дах эмнэлгийн тусламжийн үйл ажиллагаа ихээхэн хүндрэлтэй байна. Хаягдлын урт хугацааны хор уршиг зэрэг мэдээлэл байхгүй байгаа нь хохирогчдын санааг хамгийн их зовоож буй ажээ. Трафигураг өөрт байгаа мэдээллээ хохирогчдод дэлгэ гэж Кот д'Ивуарын засгийн газар шаардаагүй юм. Түүгээр зогсохгүй Их Британид уг хэргээр иргэний хэрэг үүсгэн шалгах үеэр Трафигура хаягдлын найрлага, агууламж, түүний боломжит хор уршиг болон энэ талаар шинжлэх ухааны судалгаа хийсэн талаар мэдэгдсэн боловч шүүхээс уг мэдээллээ хохирогчид болон Кот д'Ивуарын засгийн газарт мэдээлэхийг мөн л шаардаагүй. Хүний эрүүл байх эрхэнд чухлаар нөлөөлөх хүчин зүйл хэмээн үзэхийн оронд уг асуудлыг зүгээр л иргэний хэрэгт оролцогч талуудын хоорондох хувийн асуудал хэмээн үзэж, компанийг уг мэдээллүүдээ дэлгэхийг шаардаагүй нь Их Британийн томоохон алдаа дутагдлуудан нэг юм.

Кот д'Ивуарын засгийн газар мөн л хаягдлыг урт хугацааны нөлөө, тэр дундаа байгаль орчин, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг судлаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Кот д'Ивуарын засгийн газарт:

- Бүх бүртгэлтэй хохирогч иргэдийг төрөөс нөхөн төлбөр авах боломжоор хангах
- Иргэдийн эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж буй талаар судалгаа явуулж, үнэлгээ хийлгэх
- Их Британийн шүүхээс гадуур шийдвэрлэсэн гэрээний нөхөн төлбөрийн мөнгийг шамшигдуулсан хэргийг шалган, холбогдох этгээдүүдийг шүүхэд татах
- Хорт бодисыг хууль бусаар экспортлох, импортлохоос сэргийлэн Кот д'Ивуарын хууль, тогтоомж, практикт өөрчлөлт оруулан, энэ тухайгаа олон нийтэд мэдээллэх
- Кот д'Ивуарын хуулинд өөрчлөлт оруулан эрүүгийн хэрэгт компани, корпорацийг татдаг болгох
- Шүүхээс гадуур шийдвэрлэх гэрээний хууль зүйн үндэслэлийг шалгах, Трафигурад ял шийтгэлээс зугатах боломж олгох үндэслэл бий эсэхийг судлах

Нидерландын засгийн газарт:

- Нидерландад үйл ажиллагаа явуулдаг эсэхээс үл хамааран Нидерландад үүсгэн байгуулагдсан аливаа компани нь байгаль орчин, хүний эрхэд учруулсан хохирол учруулсан аливаа ажиллагаандаа хариуцлага хүлээх ёстой. Үүнд мөн гадаадад үйлдсэн гэмт хэрэг ч мөн хамаарна.
- Кот д'Ивуарын засгийн газартай хамтран химийн бодист өртсөн иргэдийн эрүүл мэндийг хянах, эрүүл мэндийн судалгаа явуулан, урт хугацааны сөрөг нөлөөг байгаа эсэхийг тогтоох

Их Британийн засгийн газар нь Трафигурагийн эсрэг эрүүгийн хэрэг үүсгэх боломжуудыг судлах

Норвегийн засгийн газар нь компаниудыг гадаад оронд үйлдсэн хэргийнх төлөө мөрдөн шалгаж, шүүх арга хэмжээ авахтай холбогдуулан хууль эрхзүйн орчин эргэн харж, шалгах нь зүйтэй.

Европын холбоо болон түүний гишүүн орнуудад:

- Компаниуд хүний эрх, байгаль орчныг хүндэтгэн хамгаалах, хуульд заасан хүний эрхийн үүрэг хариуцлагаа биелүүлэхийг шаардсан хэм хэмжээг бий болгох
- Компанийн явуулж буй үйл ажиллагаа нь хүний эрх болон байгаль орчинд чухам ямар нөлөө үзүүлэх мөн ямар нөлөө үзүүлж болох тухай мэдээллийг зайлшгүй дэлгэдэг болох, нийгэм, байгаль орчны нөлөөллийн үнэлгээг дэлгэх
- Африкийн Холбооны бүх орон Бамакогийн Конвенц, Базелийн Конвенц болон Вазелийн Конвенцийн Хориглох тухай Нэмэлт Өөрчлөлтийг нэн даруй соёрхон батлах, эдгээр шаардлагуудыг улс орныхоо хууль тусгах

Бусад бүх улс оронд:

- Компаниудыг (хуулийн этгээд) эрүүгийн хэрэгт татдаг эрхзүйн тогтолцоо бүрдүүлэх
- Эрхзүйн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авах: (а) компаниуд өөрсдийн үйл ажиллагаанд байгаль орчин, хүний эрхийг хүндлэх (б) гадаад улсад үйлдсэн гэмт хэрэгт нь тухайн компанийг шүүхэд татах, мөрдөн шалгах зэрэг нөхцлүүдийг бий болгох үүднээс эрхзүйн орчноо эргэн үзэх.
- Далайн аялалын үеэр шингэн ачааг холихгүй байх, усан онгоцон дээр боловсруулах үйлдвэрлэл явуулахгүй байх тухай Олон улсын далайн байгууллагын

хориог үр дүнтэй хэрэгжүүлэх. Усан онгоцон дээр холих, боловсруулах үйл ажиллагаа явуулсан тохиолдолд гарсан хаягдлыг Базелийн Конвенцийн дагуу шийдвэрлэх

■ Өндөр хөгжилтэй орнуудаас хөгжиж буй орнууд руу аюултай хаягдал экспортлохыг хориглодог Базелийн Конвенц ба түүний Хориглох тухай Нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах

Базелийн Конвенцид нэгдсэн улс орнууд нь coker naphtha-г Базелийн Конвенциор аюултай бодис хэмээн хүлээн зөвшөөрөх.

Трафигура нь уг хаягдал, түүний болзошгүй нөлөөллүүдийн тухай өөрт буй бүхий л мэдээллээ олон нийтэд мэдээллэх.



ХОРТ БОДИСЫН ҮНЭН

Кот д'Ивуарын Абиджан хотын иргэд 2006 оны 8 дугаар сарын 20-ний өглөө сэрэхэд хот тэр чигтээ нэгэн үнэрт автсан байв. Гэрчүүдийн дүрсэлж байгаагаар их өтгөн, амьсгал боосон, муудсан өндөг, сармис, газ болон бензин холилдсон сонин үнэр байжээ. Энэ нь хотын эргэн тойронд сургууль, гэр, ажил, ногооны талбай зэрэг 18 газар шөнийн цагаар асгаж хаясан хорт хаягдлаас ялгарч буй үнэр байв.

Тэвчихийн аргагүй үнэр олныг нилээдгүй түгшээж байсан бол үүнээс улбаалсан биет илрэлүүд нь жинхэнэ сандралд хүргэсэн юм. Мянга мянган хүмүүс дотор эвгүйргэх, толгой өвдөх, бөөлжих, гэдэс өвдөх мөн арьс, нүд загатнах зэрэг зовиур амсжээ. Хорт бодисыг хаяснаас хойших хугацаанд дээрх зовиур бүхий хэдэн арван мянган хүн тусламж авахаар эмнэлэгт хандсан байна. 2006 оны 10 дугаар сарын байдлаар эмнэлэгт 100,000 гаруй хүн хаягдлын улмаас хандсан тухай бүртгэгджээ. Орон нутгийн эрх баригчид 15-17 хүн хаягдлын уршгаар нас барсан хэмээн үзжээ.

2006 оны 8 дугаар сард Абиджанд хаясан хаягдал Трафигура гэх газрын тос борлуулдаг компанийх байсан юм. Уг хаядал нь Трафигура компанийн захиалгаар Пробо Коала гэх усан онгоцоор Кот д'Ивуар буюу Зааны ясан эрэг улсад ирсэн ажээ. Гэхдээ уг хаягдал нь Европт бий болсон бөгөөд олон улсын хуулийн дагуу Зааны ясан эрэгт очих үндэслэлгүй юм.

Абиджанд болсон хэргийг Их Британийн шүүхийн оролцоотойгоор Трафигура компанийн дотоод цахим шууданг шалгах зэргээр бүтэн 3 жил мөрдөн шалгасны эцэст уг хаягдлыг хаяхад Трафигура компанийн гаргасан шийдвэрүүд зайлшгүй үр дагавар авчирсан болохыг Эмнести Интернэшнл болон Грийнпийс байгууллага олж тогтоосон юм.

Мөрдөн шалгах явцад мөн олон засгийн газрууд хүн ам, байгаль орчныг үр дүнтэй хамгаалж чадахгүй байгаа, олон улсын хуулийг сахиулах ёстой аливаа улсын тогтолцоо үндэстэн дамнасан корпорациудыг гүйцэж ажиллаж чадахгүй байгааг, үүний улмаас иймэрхүү компани, корпорациуд нь шүүн таслах ажиллагаанаас зугатаж, ял шийтгэлгүй ажиллах боломжийг олгож байгааг илрүүлсэн юм. Түүнчлэн бүх засгийн газар нөхцөл байдлыг үр дүнтэй залруулж чадахгүй байгааг харуулж байна.

Дэлгэрэнгүй тайланг: www.amnesty.mn цахим хуудаснаас үзнэ үү.

ISBN 978-0-86210-478-8



9 780862 104788 >